

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД

2025.12.20

Гомдол гаргах нь

Хэнээс: Нэхэмжлэгч О.Батмөнх

Хэргийн дугаар: 221/ШШ2025/0034

Гомдлын агуулга: Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангуулж өгөх тухай

Нэхэмжлэгч О.Батмөнх миний бие Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд нарын 2024.12.25-ны өдрийн 251 дүгээр тогтоолын дагуу "Монополийн эсрэг газар"-ын орон тооны гишүүний албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн гэж үзэн нэхэмжлэл гаргасан. Давж заалдах шатны шүүх тус нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бөгөөд энэхүү гомдлоор уг шийдвэрийг дараах үндэслэлүүдээр хүчингүйд тооцуулахыг хүсэж байна.

1. Дээр дурдсан тогтоолыг гаргахдаа сонсох ажиллагааг огт зохион байгуулаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 27.5-д заасан "оролцогчийн тайлбар, санал гаргах боломжийг хангах" шаардлагыг хангаагүйг нотлоно.

2. "Өрсөлдөөний тухай хууль"-ийн 17.5, 18.1, 18.2-т заасан бүрэн эрхийн хугацаа, дуусгавар болох нөхцөлийг буруу хэрэглэсэн. Хуулиар Монополын эсрэг газрын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил (энэ заалт нь тухайн гишүүний баталгаа билээ) бөгөөд нэг удаа улируулан томилж болох, бүрэн эрх нь дараагийн дарга, гишүүн томилогдсоноор дуусгавар болохоор тусгайлан зохицуулсан байдаг (18.1, 18.2). Гэтэл нэхэмжлэгчийг чөлөөлөх үндэслэлийг байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбон тайлбарласан нь тусгай хуулийн дээрх зохицуулалтыг үл харгалзан, эрх зүйн үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж үзэхэд хүргэж байна.

3. Албан тушаал байхгүй болоогүй, зөвхөн нэршлийн өөрчлөлт хийсэн нь "бүтцийн өөрчлөлт"-өөр чөлөөлөх хууль зүйн үндэслэл биш. Хариуцагчаас өгсөн тайлбараар уг албан тушаал бүр мөсөн байхгүй болоогүй, зөвхөн нэршил өөрчлөгдсөн болох нь тогтоогдсон. Ийм тохиолдолд өмнөх томилгоог хүчингүй болгож, албан тушаалтныг чөлөөлөх үндэслэл үүсэхгүй бөгөөд сонгон шалгаруулалт, томилгооны тусгай журам, хугацааг баримтлах үүрэгтэй.

4. Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн тогтоол болон Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 251 дүгээр тогтоолын хэрэгжилт хооронд зөрчилтэй байна. Их Хурлын тогтоол батлагдсан тохиолдолд бүтцийн өөрчлөлтийн хэрэгжилтийг хуульд нийцүүлэн, тухайн албан тушаалд өөр хүн томилохгүй байхаар хугацааны зохицуулалт мөрдөгдөх ёстой байтал хариуцагч

байгууллагаас ижил төрлийн албан тушаалд бусад этгээдийг томилсон нь эрх зүйн үндэслэлгүй шийдвэрийн илэрхий шинж юм.

5. Төрийн албаны тухай хуулийн 62.1.3-т заасан баталгаа О.Батмөнх надад хамаарахгүй гэсэн атлаа тус байгууллага нь Төрийн албаны тухай хуулийг надад тэтгэмж олгохдоо хэрэглэсэн байдаг. Тэтгэмж олгох болохоор Төрийн албан хаагч болоод ажлаас халагдах болохоор Монгол Улсын Ерөнхий сайдын хэнийг ч хамаагүй ажилд аваад хүссэн үедээ халж болно гэсэн утга бүхий тайлбарыг өгж байгаа нь Ерөнхий сайдын эрх хэмжээг хуулиас дээгүүр тавьсан, хэт нэг талыг барьсан дүгнэлт өгсөн, зарим заалтыг шууд хэрэглэсэн нь тусгай хуулийн зохицуулалтыг үл харгалзсан, хууль мушгин тайлбарласан хэрэг.

6. Шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч Г.Маргад-Эрдэнэ нь хурлын төгсгөлд -миний бие анх удаа ийм хуралд орж үзэж байна, мөн хуулийн хүн биш тул энэ нэхэмжлэгч талыг дэмжих байр суурьтай байна, нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй байна гэж байхад шүүхээс дүгнэхдээ түүнийхээ хууль зүйн гаргалгааг тодорхойлж чадаагүй гэх хэсгийг үнэхээр ойлгохгүй байна. Иргэдийн төлөөлөгч гэдэг хүн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59.1-д заасны дагуу эрх зүйн бүрэн чадамжтай, 25-60 хүртэл насны Монгол Улсын иргэн байх; тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх; эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг сонгодог. Энэ хуулинд болон холбогдох бусад дүрэм журмуудад Иргэдийн төлөөлөгчийг хуулийн мэдлэгтэй, хууль зүйн гаргалгааг тодорхойлох чадвартай иргэнийг сонгоно гэж заагаагүй байдаг. Түүнчлэн дээрх хуулийн 66.6-д Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ, 66.7-д Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж (тодорхойлох хэсэгт Иргэдийн төлөөлөгч гэж үг үсэг байхгүй), уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана гэж тус тус заасан байхад үндэслэх хэсэгт хууль зүйн дүгнэлт өгөөгүй байх тул дүгнэлт өгөх шаардлагагүй хэмээсэн. Түүнчлэн тус хуулийн 66.8-д Давж заалдах шатны шүүх хуульд заасан тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 66.7-д заасны дагуу шийдвэртээ тусгана, харин тусгаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно гэж тус тус тодорхой заалтуудыг хуулинд оруулаад байхад шүүх үүнийг харгалзан үзээгүй.

7. Тэтгэмжийн хувьд Өрсөлдөөний хуулиараа би тухайн ажлаас гарсан уу үгүй юу эдгэх ёстой эрх билээ.

8. Тус шүүх хуралд оролцож байсан шүүгч З.Ганзориг нь хэдий хурлын өмнө О.Батмөнх миний оронд ажилд орсон Ц.Мөнхбатын 10 жилийн ангийн хүүхэд, гэдгээ түүнчлэн Ц.Мөнхбаттай 10 жил төгссөноос хойш уулзаагүй гэх тайлбарыг өгдөг ч, энэ шийдвэрийг уншихаар миний бие өөрийн эрхгүй Ц.Мөнхбатыг нөлөөлсөн байх магадлалтай гэх эргэлтээ төрж байна.

Иймд Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, нэхэмжлэгч О.Батмөнх намайг өмнөх албан тушаалд нь эргүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацаанд олгох байсан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, 251 тоот Захиргааны актын хууль бус байдлыг тодорхойлон хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангуулж өгөхийг хүсье.

Хавсралтаар:

1. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт



Нэхэмжлэгч

О.Батмөнх

Утас: 88110334;88117422